



ҮНДЭСНИЙ  
СТАТИСТИКИЙН  
ХОРОО

ЭДИЙН ЗАСГИЙН  
ХӨГЖИЛД **ЖИЖИГ, ДУНД**  
ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ОРУУЛЖ  
БУЙ ХУВЬ НЭМЭР

**2021**

Улаанбаатар хот  
2022 он



ЭДИЙН ЗАСГИЙН ХӨГЖИЛД  
ЖИЖИГ, ДУНД ҮЙЛДВЭРЛЭЛИЙН  
ОРУУЛЖ БУЙ ХУВЬ НЭМЭР  
(2021 оны танилцуулга)

Улаанбаатар хот  
2022 он

ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ХОРОО  
Вэб хаяг: [www.nso.mn](http://www.nso.mn) , [www.1212.mn](http://www.1212.mn)  
Утас: 1900-1212

Танилцуулгыг бэлтгэсэн:  
БХАГ-ын ҮТХ-ийн дарга Б.Баярмаа  
Утас: 51-262767

Танилцуулгыг хянасан:  
БХАГ-ын дарга Б.Саранчимэг

## Гарчиг

Товчилсон үгийн жагсаалт .....	3
Хүснэгтийн жагсаалт .....	4
Зургийн жагсаалт .....	4
Жижиг, дунд үйлдвэрлэлийн эдийн засагт оруулж буй хувь нэмэр .....	5
1. ЖДҮ-ийн нэмэгдэл өртөг, үйл ажиллагааны салбараар .....	6
2. ЖДҮ-ийн нэмэгдэл өртөг, бүс, аймгаар .....	9
3. ЖДҮ-ийн барааны экспорт, импорт .....	10
Дүгнэлт .....	13

### Товчилсон үгийн жагсаалт

ААН	Аж ахуйн нэгж
ААНБ	Аж ахуйн нэгж, байгууллага
ГЕГ	Гаалийн ерөнхий газар
ДНБ	Дотоодын нийт бүтээгдэхүүн
ЖДҮ	Жижиг, дунд үйлдвэрлэл
ЖДҮҮЭ	Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгч
НӨ	Нэмэгдэл өртөг
ХАА	Хөдөө аж ахуй
ХХЭ	Хувиараа хөдөлмөр эрхлэгч

## Хүснэгтийн жагсаалт

- Хүснэгт 1. ДНБ, ЖДҮ-ийн нэмэгдэл өртөг
- Хүснэгт 2. ЖДҮ-ийн нэмэгдэл өртөг, салбараар, тэрбум төгрөг
- Хүснэгт 3. Хөдөө аж ахуйн салбарын нэмэгдэл өртөг, тэрбум төгрөг
- Хүснэгт 4. Үйлдвэрлэлийн салбарын нэмэгдэл өртөг, тэрбум төгрөг
- Хүснэгт 5. Үйлчилгээний салбарын нэмэгдэл өртөг, тэрбум төгрөг
- Хүснэгт 6. ЖДҮ-ийн нэмэгдэл өртөг, бүс, аймгаар, тэрбум төгрөг
- Хүснэгт 7. ЖДҮ-ийн экспорт, голлох барааны бүлгээр
- Хүснэгт 8. ЖДҮ-ийн импорт, голлох барааны бүлгээр

## Зургийн жагсаалт

- Зураг 1. ЖДҮ-ийн эдийн засагт оруулж буй хувь нэмэр (ДНБ-д эзлэх хувь)
- Зураг 2. ДНБ болон ЖДҮ-ийн нэмэгдэл өртгийн салбарын бүтэц
- Зураг 3. Үйлдвэрлэлийн салбарын ЖДҮ-ийн нэмэгдэл өртөг
- Зураг 4. Үйлчилгээний салбарын ЖДҮ-ийн нэмэгдэл өртөг
- Зураг 5. ЖДҮ-ийн нэмэгдэл өртгийн бүтэц, бүсээр
- Зураг 6. ЖДҮ-ийн нэмэгдэл өртгийн ДНБ-д эзлэх хувь, бүсээр
- Зураг 7. Гадаад худалдаанд оролцогч ЖДҮ-ийн ААНБ-ын нийт тоонд эзлэх хувь
- Зураг 8. Экспорт, ААНБ-ын хэмжээгээр
- Зураг 9. Импорт, ААНБ-ын хэмжээгээр
- Зураг 10. Бараа экспортлогч ЖДҮ-ийн дүнд эзлэх хувь
- Зураг 11. ЖДҮ-ийн экспорт, зарим улс орноор
- Зураг 12. Бараа импортлогч ЖДҮ-ийн дүнд эзлэх хувь
- Зураг 13. ЖДҮ-ийн Импорт, зарим улс орноор

## Жижиг, дунд үйлдвэрлэлийн эдийн засагт оруулж буй хувь нэмэр

Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ гэж ажиллах хүчний болон үйлдвэрлэлийн цар хүрээгээр цомхон, бүтээмж өндөртэй, үйлдвэрлэлийн уян хатан технологитой, зах зээлд өрсөлдөх чадвар бүхий бизнесийг ойлгоно.

Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээний салбарт хамгийн олон хүн ажиллаж, эдийн засагт тодорхой хувь нэмэр оруулдаг.

ҮСХ жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчийн тоог статистикийн бизнес регистрийн сангаас “Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай” хуулийн 3.2, 4.1.1, 7.1-р заалтыг үндэслэн тодорхойлж гаргадаг.

ЖДҮ буюу жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчдийг:

- бичил үйлдвэр, үйлчилгээ эрхлэгч (10 хүртэл ажилтантай, жилийн 300.0 сая төгрөг хүртэл борлуулалтын орлоготой аж ахуйн нэгж),
- жижиг үйлдвэр, үйлчилгээ эрхлэгч (10-50 хүртэл ажилтан, жилийн 300.0 сая-1.0 тэрбум төгрөг хүртэл борлуулалтын орлоготой аж ахуйн нэгж),
- дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгч (50-200 хүртэл ажилтан, жилийн 1.0-2.5 тэрбум төгрөг хүртэл борлуулалтын орлоготой аж ахуйн нэгж) гэж ангилсан байна.


Мөн хуулийн 7 дугаар зүйлд “Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчид хамаарахгүй этгээд”-ийг заасан байдаг. ЖДҮҮЭ-д хамаарахгүй салбаруудыг эдийн засгийн үйл ажиллагааны салбарын ангиллын дагуу авч үзвэл, 18 салбарын нийт 108 анги (салбарын ангиллын 4 оронгийн түвшин)-ийн үйл ажиллагаа байна.

### ХҮСНЭГТ 1. ДНБ, ЖДҮ-ИЙН НЭМЭГДЭЛ ӨРТӨГ, 2020, 2021 он

Төрөл	ДНБ <sup>1</sup> , тэрбум төгрөг		ДНБ-д эзлэх хувь		Жилийн өөрчлөлт, хувиар	
	2020	2021	2020	2021	2020	2021
<b>Бүгд</b>	<b>32 195.7</b>	<b>37 397.2</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>0.1</b>	<b>16.2</b>
ЖДҮ	1 810.0	2 073.8	5.6	5.5	36.0	14.6
ЖДҮ-д хамаарахгүй	30 385.7	35 323.4	94.4	94.5	-1.4	16.3

ЖДҮ-т бий болгосон нэмэгдэл өртгийн хэмжээ 2021 онд 2.1 их наяд төгрөг болж, өмнөх оноос 474.0 тэрбум төгрөг буюу 14.6 хувиар нэмэгджээ. ЖДҮ-ийн эдийн засагт оруулах хувь нэмэр буюу ДНБ-д эзлэх хувь 5.5 болж, өмнөх оноос 0.1 нэгж хувиар буурсан байна.

### ЗУРАГ 1. ЖДҮ-ИЙН ЭДИЙН ЗАСАГТ ОРУУЛЖ БУЙ ХУВЬ НЭМЭР (ДНБ-д эзлэх хувь)



<sup>1</sup> ДНБ, үндсэн үнээр, мөн үл хөдлөх хөрөнгийн салбарт тусгадаг Өөрийн эзэмшлийн орон сууцны хийсвэр түрээсийн тооцооллыг оруулаагүй.

## 1. ЖДҮ-ийн нэмэгдэл өртөг, үйл ажиллагааны салбараар

ЖДҮ-ийн үйл ажиллагааг эдийн засгийн салбараар авч үзвэл, хөдөө аж ахуйн салбарын ЖДҮ-ийн нэмэгдэл өртгийн салбарын нэмэгдэл өртөгт эзлэх хувь 2021 онд 4.0, үйлдвэрлэлийн салбарынх 3.1, үйлчилгээний салбарынх 8.7 боллоо (Хүснэгт 2).

### ХҮСНЭГТ 2. ЖДҮ-ИЙН НЭМЭГДЭЛ ӨРТӨГ, салбараар, 2020, 2021 он, тэрбум төгрөг

	ДНБ(НӨ) <sup>2</sup>			ЖДҮ-ийн нэмэгдэл өртөг			ЖДҮ-ийн НӨ-ийн салбарын НӨ-т эзлэх хувь	
	2020	2021	<u>2021</u> % 2020	2020	2021	<u>2021</u> % 2020	2020	2021
<b>Бүгд</b>	<b>32 195.7</b>	<b>37 397.2</b>	<b>116.2</b>	<b>1 810.0</b>	<b>2 073.8</b>	<b>114.6</b>	<b>5.6</b>	<b>5.5</b>
Хөдөө аж ахуй	4 856.1	5 733.3	118.1	88.4	227.5	257.2	1.8	4.0
Үйлдвэрлэл	13 876.3	16 148.4	116.4	486.6	493.4	101.4	3.5	3.1
Уул уурхай, олборлолт	8 722.1	10 753.7	123.3	-	-	-	-	-
Боловсруулах	2 904.9	3 096.4	106.6	207.4	205.3	99.0	7.1	6.6
Цахилгаан, хий, уур, усан хангамж	881.8	929.5	105.4	5.3	3.8	71.6	0.6	0.4
Барилга	1 367.5	1 368.8	100.1	273.9	284.3	103.8	20.0	20.8
Үйлчилгээ	13 463.3	15 515.5	115.2	1 234.9	1 353.0	109.6	9.2	8.7
Худалдаа	3 436.8	4 069.6	118.4	632.6	691.5	109.3	18.4	17.0
Тээвэр	1 411.8	1 597.1	113.1	131.8	105.2	79.8	9.3	6.6
Байр, сууц, нийтийн хоол	321.4	383.1	119.2	85.2	99.3	116.5	26.5	25.9
Бусад үйлчилгээ	8 293.3	9 465.8	114.1	385.4	457.0	118.6	4.6	4.8

### ЗУРАГ 2. ДНБ БОЛОН ЖДҮ-ИЙН НЭМЭГДЭЛ ӨРТГИЙН САЛБАРЫН БҮТЭЦ, хувиар



ДНБ-д хөдөө аж ахуйн салбар 15.3 хувь, үйлдвэрлэлийн салбар 43.2 хувь, үйлчилгээний салбар 41.5 хувийг эзэлж байгаа бол ЖДҮ-ийн нэмэгдэл өртгийн 23.8 хувь нь үйлдвэрлэлийн салбарт, 65.2 хувь нь үйлчилгээний салбарт ногдож байна.

#### 1.1 Хөдөө аж ахуйн салбар

Манай улсын хувьд хөдөө аж ахуйд мал аж ахуйн салбар зонхилдог, хөдөө аж ахуйн салбарын нэмэгдэл өртгийн 92 хувийг мал аж ахуй, 7 хувийг газар тариалан, 1 хувийг ойн аж ахуй, хөдөө аж ахуйн бусад салбар бүрдүүлдэг. Иргэд, малчид ЖДҮ-д хамаарахгүй учир (шинэчилсэн хуулийн дагуу) ХАА-н салбарын ЖДҮ-ийн нэмэгдэл өртөг салбартаа дунджаар 4.0 хувь байна.

### ХҮСНЭГТ 3. ХӨДӨӨ АЖ АХУЙН САЛБАРЫН НЭМЭГДЭЛ ӨРТӨГ, тэрбум төгрөг

	Салбарын НӨ			ЖДҮ			ЖДҮ-ийн НӨ-ийн салбарын НӨ-т эзлэх хувь	
	2020	2021	<u>2021</u> % 2020	2020	2021	<u>2021</u> % 2020	2020	2021
Хөдөө аж ахуй	4 856.1	5 733.3	118.1	88.4	227.5	257.2	1.8	4.0

## 1.2 Үйлдвэрлэлийн салбар

Үйлдвэрлэлийн салбар нь 2021 онд ДНБ<sup>2</sup>-ий 43.2 хувийг бүрдүүлсэн бол уг салбарын ЖДҮ-ийн нэмэгдэл өртгийн хэмжээ салбартаа 3.1 хувийг бүрдүүлжээ.

Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчийн тодорхойлолтын дагуу үйлдвэрлэл эрхлэгч ЖДҮ-д уул уурхай, олборлолтын салбар, цахилгаан, хий, уур, ус хангамж, ундаа үйлдвэрлэл, тамхи үйлдвэрлэл, металл боловсруулах, төмөр зам, авто замын байгууламж барих үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгж, байгууллага болон төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн нэгж, байгууллага, гадаадтай хамтарсан, гадаад улсын байгууллагууд хамаарахгүй учир үйлдвэрлэлийн салбарын ЖДҮ-ийн нэмэгдэл өртгийн хэмжээ харьцангуй бага түвшинд байна.


### ХҮСНЭГТ 4. ҮЙЛДВЭРЛЭЛИЙН САЛБАРЫН НЭМЭГДЭЛ ӨРТӨГ, тэрбум төгрөг

	Салбарын НӨ			ЖДҮ			ЖДҮ-ийн НӨ-ийн салбарын НӨ-т эзлэх хувь	
	2020	2021	2021 % 2020	2020	2021	2021 % 2020	2020	2021
<b>Бүгд</b>	<b>13 876.3</b>	<b>16 148.4</b>	<b>116.4</b>	<b>486.6</b>	<b>493.4</b>	<b>101.4</b>	<b>3.5</b>	<b>3.1</b>
Уул уурхай, олборлолт	8 722.1	10 753.7	123.3	-	-	-	-	-
Боловсруулах үйлдвэрлэл	2 904.9	3 096.4	106.6	207.4	205.3	99.0	7.1	6.6
Цахилгаан, хий, уур, усан хангамж	881.8	929.5	105.4	5.3	3.8	71.6	0.6	0.4
Барилга	1 367.5	1 368.8	100.1	273.9	284.3	103.8	20.0	20.8

Үйлдвэрлэлийн салбарын ЖДҮ-ийн бий болгосон нэмэгдэл өртгийн хэмжээ 2021 онд 493.4 тэрбум төгрөг болж, өмнөх оноос 1.4 хувиар нэмэгдсэн байна.

Үйлдвэрлэлийн салбарын ЖДҮ-ийн нэмэгдэл өртгийн хэмжээ тухайн салбарын 3.1 хувийг, нийт ЖДҮ-ийн нэмэгдэл өртөгт 23.8 хувийг бүрдүүлсэн байна.

### ЗУРАГ 3. ҮЙЛДВЭРЛЭЛИЙН САЛБАРЫН ЖДҮ-ИЙН НЭМЭГДЭЛ ӨРТӨГ





### 1.3 Үйлчилгээний салбар

Үйлчилгээний салбар (оны үнээр) 2021 онд ДНБ<sup>2</sup>-ий 41.5 хувийг бүрдүүлсэн. Үйлчилгээ эрхлэгч ЖДҮ-ийн нэмэгдэл өртгийн хэмжээ нийт үйлчилгээний салбарын 8.7 хувийг бүрдүүлжээ.

Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчийн тодорхойлолтын дагуу үйлчилгээ эрхлэгч ЖДҮ-д санхүү, даатгал, үл хөдлөх хөрөнгө, төрийн удирдлага, батлан хамгаалах үйл ажиллагаа, боловсрол, гишүүнчлэл бүхий байгууллагын үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгж, байгууллага болон төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн нэгж, байгууллага, гадаадтай хамтарсан, гадаад улсын байгууллагууд хамаарахгүй.

#### ХҮСНЭГТ 5. ҮЙЛЧИЛГЭЭНИЙ САЛБАРЫН НЭМЭГДЭЛ ӨРТӨГ, тэрбум төгрөг

	Салбарын НӨ			ЖДҮ			ЖДҮ-ийн НӨ-ийн салбарын НӨ-т эзлэх хувь	
	2020	2021	$\frac{2021}{2020}$ %	2020	2021	$\frac{2021}{2020}$ %	2020	2021
<b>Бүгд</b>	<b>13 463.3</b>	<b>15 515.5</b>	<b>115.2</b>	<b>1 234.9</b>	<b>1 353.0</b>	<b>109.6</b>	<b>9.2</b>	<b>8.7</b>
Бөөний, жижиглэн худалдаа	3 436.8	4 069.6	118.4	632.6	691.5	109.3	18.4	17.0
Тээвэр, агуулах	1 411.8	1 597.1	113.1	131.8	105.2	79.8	9.3	6.6
Байр, сууц, хоол хүнсээр үйлчлэх	321.4	383.1	119.2	85.2	99.3	116.5	26.5	25.9
Бусад үйлчилгээ	8 293.3	9 465.8	114.1	385.4	457.0	118.6	4.6	4.8

Үйлчилгээний салбарын ЖДҮ-ийн бий болгосон нэмэгдэл өртгийн хэмжээ 2021 онд 1.4 их наяд төгрөг болж, өмнөх оноос 9.6 хувиар нэмэгджээ.

Үйлчилгээний салбарын ЖДҮ-ийн нэмэгдэл өртгийн хэмжээ тухайн салбарын 8.7 хувийг, нийт ЖДҮ-ийн нэмэгдэл өртөгт 65.2 хувийг эзэлж байна.

Дэд салбараар авч үзвэл, 2021 онд бөөний болон жижиглэн худалдааны салбарын ЖДҮ нийт салбарынхаа 17.0 хувь, байр, сууц, хоол хүнсээр үйлчлэх салбарынх 25.9 хувь байгаа нь бусад салбараас өндөр байна.

#### ЗУРАГ 4. ҮЙЛЧИЛГЭЭНИЙ САЛБАРЫН ЖДҮ-ИЙН НЭМЭГДЭЛ ӨРТӨГ




## 2. ЖДҮ-ийн нэмэгдэл өртөг, бүс, аймгаар

ЖДҮ-ийн нэмэгдэл өртгийн оролцоог бүсээр авч үзвэл, 2021 оны гүйцэтгэлээр баруун бүсэд 3.2 хувь, хангайн бүсэд 7.3 хувь, төвийн бүсэд 13.3 хувь, зүүн бүсэд 3.6 хувь, Улаанбаатарт 72.6 хувь нь ногдож байна (Зураг 7).

Бүс нутгийн ЖДҮ-ийн нэмэгдэл өртгийн ДНБ-д эзлэх хувь баруун бүс, хангайн бүс, зүүн бүсэд улсын дунджаас доогуур, харин төвийн бүс болон Улаанбаатар улсын дунджаас дээгүүр байна.

ЗУРАГ 5. ЖДҮ-ИЙН НӨ-ИЙН БҮТЭЦ, 2020, 2021 он  
ЗУРАГ 6. ЖДҮ-ИЙН НӨ-ИЙН ДНБ-Д ЭЗЛЭХ ХУВЬ, бүсээр, 2021 он




ХҮСНЭГТ 6. ЖДҮ-ИЙН НЭМЭГДЭЛ ӨРТӨГ, бүс, аймгаар, тэрбум төгрөг

	ДНБ <sup>2</sup>			ЖДҮ-ийн нэмэгдэл өртөг			ЖДҮ-ийн НӨ-ийн ДНБ-д эзлэх хувь	
	2020	2021	2021 % 2020	2020	2021	2021 % 2020	2020	2021
<b>Бүгд</b>	<b>32 162.9</b>	<b>32 195.7</b>	<b>100.1</b>	<b>1 810.0</b>	<b>2 073.8</b>	<b>114.6</b>	<b>5.6</b>	<b>5.5</b>
Баруун бүс	2 059.2	2 349.8	114.1	75.1	65.4	87.1	3.2	2.5
Баян-Өлгий	404.2	447.0	110.6	12.2	10.1	83.4	2.7	2.0
Говь-Алтай	329.7	405.3	122.9	10.9	10.0	91.4	2.7	2.7
Завхан	417.5	480.6	115.1	9.6	9.4	98.9	2.0	1.8
Увс	387.8	464.8	119.8	20.5	15.4	75.0	4.4	2.7
Ховд	520.0	552.1	106.2	21.9	20.5	93.3	4.0	3.0
Хангайн бүс	4 735.7	4 666.5	98.5	136.7	151.7	111.0	2.9	2.6
Архангай	591.0	630.0	106.6	10.8	16.4	151.9	1.7	2.3
Баянхонгор	437.2	554.4	126.8	10.0	11.7	116.3	1.8	3.6
Булган	358.6	390.2	108.8	16.5	21.5	130.6	4.2	4.5
Орхон	2 042.3	1 797.9	88.0	57.7	56.0	97.2	3.2	1.9
Өвөрхангай	625.1	633.0	101.3	20.5	20.5	100.3	3.2	3.5
Хөвсгөл	681.7	661.0	97.0	21.2	25.5	120.0	3.2	3.2
Төвийн бүс	3 415.7	3 980.4	116.5	202.4	276.5	136.6	5.1	5.9
Говьсүмбэр	105.2	118.8	113.0	5.2	4.6	89.1	4.4	3.5
Дархан-Уул	488.4	619.0	126.8	48.5	51.4	105.8	7.8	7.1
Дорноговь	437.7	478.5	109.3	16.8	16.9	100.7	3.5	2.9
Дундговь	361.7	337.2	93.2	8.6	7.7	90.1	2.5	2.4
Өмнөговь	775.3	981.2	126.6	48.0	48.4	100.8	4.9	4.7
Сэлэнгэ	642.5	765.0	119.1	39.3	79.0	201.0	5.1	7.2
Төв	605.0	680.7	112.5	36.1	68.5	189.8	5.3	8.3
Зүүн бүс	1 887.7	1 676.8	88.8	56.8	74.3	130.7	3.4	3.5
Дорнод	924.8	756.2	81.8	30.4	41.6	136.9	4.0	4.3
Сүхбаатар	502.0	455.6	90.8	10.4	10.4	99.7	2.3	1.8
Хэнтий	460.9	465.0	100.9	16.0	22.3	139.3	3.4	3.8
Улаанбаатар	20 064.6	19 522.2	97.3	1 339.0	1 506.0	112.5	6.9	6.9

### 3. ЖДҮ-ийн барааны экспорт, импорт


Гадаад худалдаанд оролцогч ЖДҮ-ийн оролцоо жилээс жилд буурах хандлагатай байна. 2021 онд бараа импортлогч ААНБ-ын эзлэх хувь 69.8, экспортлогч ААНБ-ынх 43.4 байгаа нь 2019 онтой харьцуулахад импортлогч ЖДҮ 6.5 нэгж хувь, экспортлогч ЖДҮ 4.2 нэгж хувиар буурчээ.

ЗУРАГ 7. ГАДААД ХУДАЛДААНД ОРОЛЦОГЧ ЖДҮ-ИЙН ААНБ-ЫН НИЙТ ТООНД ЭЗЛЭХ ХУВЬ




Зураг 8, 9-т барааны экспорт, импортын хэмжээг ЖДҮ (бичил, жижиг, дунд үйлдвэрлэгч) болон ЖДҮ-ээс бусад гэж ангилан харуулсан. Экспортын хувьд 2021 онд ЖДҮ ААНБ-ын тооны хувьд 43.4 хувь байгаа ч экспортын хэмжээний хувь 2.4 хувийг эзэлж байна. Харин импортын хувьд ААНБ-ын тооны хувьд 62.1 хувь, импортын хэмжээний хувьд 9.7 хувь байна.

ЗУРАГ 8. ЭКСПОРТ, ААНБ-ЫН ХЭМЖЭЭГЭЭР, 2021 он




ЗУРАГ 9. ИМПОРТ, ААНБ-ЫН ХЭМЖЭЭГЭЭР, 2021 он




## Экспорт

Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчид 2021 онд 621.0 тэрбум төгрөгийн бараа экспортод гаргасан нь нийт барааны экспорт<sup>2</sup>-ын 2.4 хувийг эзэлж байна.

### ЗУРАГ 10. БАРАА ЭКСПОРТЛОГЧ ЖДҮ-ИЙН ДҮНД ЭЗЛЭХ ХУВЬ



### ЗУРАГ 11. ЖДҮ-ИЙН ЭКСПОРТ, зарим улс орноор



ЖДҮ-ийн экспортыг гаргаж байгаа улс орноор авч үзвэл, 2021 онд БНХАУ руу 481.7 тэрбум төгрөгийн бараа экспортолсон байна. Энэ нь ЖДҮ-ийн экспортын 90.4 хувийг эзэлж байгаа бөгөөд 2015 онтой харьцуулахад 11.4 нэгж хувиар нэмэгджээ.

ЖДҮ-ийн экспортод гаргасан барааг ангилан авч үзвэл 2021 онд экспортын 52.4 хувь нь мал, амьтны ноос, ноолуур, 29.4 хувь нь эрдэс бүтээгдэхүүний экспорт эзэлж байна.

### ХҮСНЭГТ 7. ЖДҮ-ИЙН ЭКСПОРТ, голлох барааны бүлгээр

Барааны бүлэг	HS код	2018	2019	2020	2021	2018	2019	2020	2021
		тэрбум төгрөг				дүнд эзлэх хувь			
<b>Бүгд</b>		<b>715.9</b>	<b>591.1</b>	<b>719.5</b>	<b>621.0</b>	<b>4.1</b>	<b>2.9</b>	<b>3.4</b>	<b>2.4</b>
Мах; мал, амьтны гаралтай бусад бүтээгдэхүүн	02,05	36.5	59.8	49.9	30.2	14.5	23.2	34.3	27.8
Самар	08	18.0	0.2	0.2	14.8	65.2	99.0	51.1	6.1
Тослог үр жимс	12	19.1	27.0	28.2	7.8	77.2	86.0	93.9	94.7
Махан бүтээгдэхүүн	16	62.1	19.5	18.7	10.7	30.8	14.5	10.9	9.8
Эрдэс бүтээгдэхүүн	25-27	102.7	116.8	179.7	182.7	0.7	0.7	1.2	0.9
Боловсруулсан арьс шир	41	31.1	25.7	14.5	11.3	75.7	71.8	74.2	72.6
Мал, амьтны ноос, ноолуур	51	413.1	293.8	398.4	325.2	46.5	29.7	60.1	35.1
Сүлжмэл хувцас	61	13.6	12.1	11.1	11.8	14.3	9.3	10.5	10.5
Бусад бараа	-	19.7	36.3	18.8	26.5	2.5	2.1	0.3	0.8

ЖДҮ-ийн экспорт нийт барааны экспортод 2.4 хувийг эзэлж байгаа хэдий ч барааны бүлгээр авч үзвэл, 2021 онд экспортод гаргасан боловсруулсан арьс ширийн 72.6 хувийг, тослог үр жимс буюу рапсын 94.7 хувийг, мал, амьтны ноос ноолуурын экспортын 35.1 хувийг, мах, мал, амьтны гаралтай бусад бүтээгдэхүүний 27.8 хувийг ЖДҮ гаргасан байна.

<sup>2</sup> ГЕГ-ын мэдээгээр


## Импорт

Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчид 2021 онд 532.7 тэрбум төгрөгийн бараа экспортод гаргасан нь нийт барааны экспортын 2.5 хувийг эзэлж байна. ЖДҮ-ийн экспортын хэмжээ жил бүр нэмэгдэж байгаа хэдий ч ЖДҮ-ийн экспортод эзлэх хувь төдийлөн өөрчлөлтгүй байна.

ЗУРАГ 12. БАРАА ИМПОРТЛОГЧ ЖДҮ-ИЙН ДҮНД ЭЗЛЭХ ХУВЬ



ЗУРАГ 13. ЖДҮ-ИЙН ИМПОРТ, зарим улс орноор



ЖДҮ-ийн импортыг улс орноор авч үзвэл, 2021 онд БНХАУ-аас 1.0 их наяд төгрөгийн бараа импортолсон байна.

Энэ нь ЖДҮ-ийн импортын 53.7 хувийг эзэлж байгаа бөгөөд 2017 онтой харьцуулахад 5.8 нэгж хувиар нэмэгджээ.

ЖДҮ-ийн экспортод гаргасан барааг ангилан авч үзвэл 2021 онд экспортын 53.6 хувь нь мал, амьтны ноос, ноолуур, 29.5 хувь нь эрдэс бүтээгдэхүүний экспорт эзэлж байна.

ХҮСНЭГТ 8. ЖДҮ-ИЙН ИМПОРТ, голлох барааны бүлгээр

Барааны бүлэг	HS код	2018	2019	2020	2021	2018	2019	2020	2021
		тэрбум төгрөг				дүнд эзлэх хувь			
<b>Бүгд</b>		<b>1 397.2</b>	<b>1 809.1</b>	<b>1 508.0</b>	<b>1 894.0</b>	<b>9.6</b>	<b>10.9</b>	<b>10.1</b>	<b>9.7</b>
Арьс, шир, түүгээр хийсэн эдлэл	IV	140.0	111.3	108.2	144.9	12.9	9.4	8.8	8.4
Мод, модон эдлэл	VIII	7.5	5.9	4.3	5.2	36.5	32.1	30.0	28.2
Хүнсний бүтээгдэхүүн, ундаа, тамхи	IX	37.8	42.6	53.7	68.0	44.9	36.6	44.0	38.6
Чулуу, гипс, цемент, керамик эдлэл	XIII	83.3	122.6	143.6	170.7	29.4	32.2	30.7	37.6
Тээврийн хэрэгсэл, тэдгээртэй холбоотой төхөөрөмж	XV	141.4	218.6	148.1	170.3	10.6	15.0	9.8	10.5
Үндсэн металл, тэдгээрээр хийсэн зүйлс	XVI	275.1	393.0	236.3	288.4	8.6	11.3	7.9	8.1
Машин, тоног төхөөрөмж, цахилгаан хэрэгсэл, тэдгээрийн эд анги	XVII	199.5	144.9	255.2	350.7	9.0	4.5	10.7	10.0
Хэмжүүр, эмнэлгийн багаж, аппарат, цаг	XVIII	71.5	52.0	41.3	43.7	26.8	21.7	14.1	12.1
Бусад бараа	-	441.0	718.2	517.4	652.2	7.3	10.9	8.8	8.1

ЖДҮ-ийн импортыг барааны бүлгээр авч үзвэл, 2021 онд импортоор оруулж ирсэн мод, модон эдлэл бүлгийн барааны 28.2 хувь, чулуу, гипс, цемент, керамик эдлэл бүлгийн барааны 37.6 хувь, хүнсний бүтээгдэхүүн, ундаа, тамхи бүлгийн барааны 38.6 хувь нь ЖДҮ-д ногдож байна.

## ДҮГНЭЛТ

Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчид 2021 онд 2.1 их наяд төгрөгийн нэмэгдэл өртөг бий болгосон нь ДНБ-ий 5.5 хувийг бүрдүүлсэн байна.

Үйлдвэрлэлийн салбарын ЖДҮ-ийн нэмэгдэл өртгийн хэмжээ 2021 онд 493.4 тэрбум төгрөг болж, үйлдвэрлэлийн салбарын нэмэгдэл өртөгт ЖДҮ 3.1 хувийг эзэлж байна.

Үйлчилгээний салбарын ЖДҮ-ийн нэмэгдэл өртгийн хэмжээ 1353.0 тэрбум төгрөг болж, үйлчилгээний салбарын нэмэгдэл өртөгт 8.7 хувийг эзэлж байна.

Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчид 2021 онд 621.0 тэрбум төгрөгийн бараа экспортолж, 1894.0 тэрбум төгрөгийн бараа импортолсон нь нийт барааны экспортын 2.4 хувь, импортын 9.7 хувийг эзэлж байна.

Экспортын 89.2 хувийг БНХАУ-д гаргасан бол импортын 53.7 хувийг БНХАУ-аас оруулж ирсэн байна.

Экспортын барааны 52.4 хувь нь мал, амьтны ноос, ноолуур, 29.4 хувь нь эрдэс бүтээгдэхүүн, 4.9 хувь нь мах, мал, амьтны гаралтай бусад бүтээгдэхүүн байна.

Импортын барааны 18.5 хувь нь машин, тоног төхөөрөмж, цахилгаан хэрэгсэл, тэдгээрийн эд анги, 15.2 хувь нь үндсэн металл, тэдгээрээр хийсэн зүйлс байна.

Эдийн засгийн үйл ажиллагааны салбараар авч үзвэл ЖДҮ-ийн нэмэгдэл өртгийн 11.0 хувийг хөдөө аж ахуйн салбар, 23.8 хувийг үйлдвэрлэлийн салбар, 65.2 хувийг үйлчилгээний салбар тус тус эзэлж байна.